

Засгийн газрын 20... оны дугаар
тогтоолын хавсралт

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БӨӨНИЙ ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН
КОМПАНИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, тасалдал, хомстол үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбогдуулан газрын тосны бүтээгдэхүүн импортлох, үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн компанийн нөөц (цаашид “компанийн нөөц” гэх)-ийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг тооцоолох, тогтоох, бүрдүүлэх, хяналт тавих, мэдээ тайлан гаргахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Компанийн нөөц бүрдүүлэх бүтээгдэхүүнд автобензин, дизелийн түлш, шатдаг хий, онгоцны түлшийг хамааруулж ойлгоно.

1.3. Энэхүү журмыг холбогдох төрийн захиргааны байгууллага, газрын тосны бүтээгдэхүүн импортлох, үйлдвэрлэл, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) аж ахуйн нэгжүүд дагаж мөрдөнө.

Хоёр. Компанийн нөөцийн нэр төрөл, хэмжээг тооцоолох, тогтоох

2.1. Компанийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг тооцохдоо тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмнөх онд импортолсон, үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээний сарын дундаж үзүүлэлтийн 60 хувиар тооцно.

2.2. Компанийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр Засгийн газар жил бүрийн 11 дүгээр сард тогтооно.

2.3. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь компанийн нөөц бүрдүүлэх тухай Засгийн газрын тогтоолд хамрагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй компанийн нөөц бүрдүүлэх, мэдээ тайлан ирүүлэх талаарх гэрээг байгуулна.

2.4. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд байгуулах Гэрээний үлгэрчилсэн загварыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

2.5. Тухайн жилийн явцад газрын тосны бүтээгдэхүүн импортлох, үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан хуулийн этгээдийн бүрдүүлэх компанийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түр тогтоож болно.

Гурав. Компанийн нөөцийг бүрдүүлэх

3.1. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 13.3 дахь заалтын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг заавал бүрдүүлнэ.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг тогтоосон нэр төрөл, тоо хэмжээгээр гэрээнд заасан агуулахад бүрдүүлэн хадгална.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг

4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь чанар, стандартын шаардлага хангасан газрын тосны бүтээгдэхүүнээр компанийн нөөцийг бүрдүүлж, технологийн дагуу хадгалах үүргийг хүлээнэ.

4.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөцийг гэрээнд заасан агуулахад хадгалах ба агуулахын үлдэгдлийг Засгийн газраас тогтоосон компанийн нөөцийн хэмжээнээс бууруулахгүй байх үүрэг хүлээнэ.

4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөц бүрдүүлэх, хадгалах үйл ажиллагаатай холбогдуулан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг чанд мөрдөн ажиллаж, гарах зардал /хадгалалтын зардал, даатгал, хэвийн хорогдол...гэх мэт/ болон эрсдлийг бүрэн хариуцна.

4.4. Компанийн нөөцийн хадгалалт, тоо хэмжээ, чанарт хяналт тавих, шалгах шаардлагатай тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг агуулахын талбайд чөлөөтэй нэвтрүүлж, өөрийн төлөөлөгчийг байлцуулан холбогдох мэдээ, баримттай танилцуулах үүрэгтэй.

4.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөц бүрдүүлэх үүргээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлэх, нөөцийг тогтоосон хэмжээнээс бууруулахыг хориглоно.

Тав. Мэдээ, тайлан

5.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн компанийн нөөцийн мэдээ, тайлан гаргах маягыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь компанийн нөөцийн талаарх сар бүрийн мэдээ, тайланг дараа сарын 05-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны

дотор эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулан газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

5.3. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн сарын мэдээ, тайланг нэгтгэн сар бүрийн 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.4. Импортоор орж ирсэн газрын тосны бүтээгдэхүүний сар, жилийн мэдээ, тайланг Гаалийн ерөнхий газар компани тус бүрээр гаргаж газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад сар бүрийн 10-ны дотор хүргүүлж байна.

5.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн борлуулалтын мэдээ тайланг улирлаар гаргаж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

Зургаа. Компанийн нөөцөд тавих хяналт

23. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн компанийн нөөц бүрдүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтэд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлж байна.

24. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Стандарт, хэмжил зүйн газраас баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн технологи, үйл ажиллагааны аргачлал” стандартын дагуу компанийн нөөцийн хэмжээ, чанарын шинжилгээ хийж бүртгэл хөтөлнө.

25. Компанийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, бүтээгдэхүүний чанарт газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

-----oO-----